

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №1: Лифтэнд суух, буух



11 давхар руу огсох замдаа 3 удаа зогсож хvн авлаа. Тэд намайг буулгаад бvгд доошоо явлаа” гэсэн инээдэмтэй ч юм шиг эмгэнэлтэй ч юм шиг явдал хэд хоног нийгмийн сvлжээгээр цацагдсан.

Лифт захиалж товчлуурыг дарахдаа та хэддvгээр давхарт зогсож байгаагаас vл хамааран явах чиглэлийнхээ товчлуурыг дарах учиртай. Оороор хэлбэл та дээшээ явах гэж байгаа бол нэгдvгээр давхарт зогсож байгаа тохиолдолд “дээшээ” товчлуурыг дарна. Харин доод давхар руугаа буух гэж байгаа бол лифтний “доошоо” товчлуурыг дарах юм. Зарим хvн “би нэгдvгээр давхарт зогсож байгаа учир лифтийг доод давхар руу дуудаж байна, тиймээс доошоо товчлуурыг дарж байж лифтийг дуудна. Ирэхээр нь дээшээ явна” гэж андуурдаг. Энэ тун буруу ойлголт юм шvв.

Мон та лифт ирэхийг хvлээн зогсохдоо хаалганы онгойх хэсгийг бvн хааж зогсоорой. Учир нь лифтнээс хvмvвс бууж ирэх магадлал ондор тул та тэдэнд зай тавин баруун гар

талаа эзлэн зогсох богоод хмввс бууж дууссаны дараа лифтэнд суугаарай. Хмввст зай тавин огч буулгахгвйгээр та дотогш нэвтрэх боломжгвй шvv дээ.

Лифт таныг орхиод явчихна гэж сандрах хэрэггвй. Хаалга нь хаагдах болоход товчлуурыг дахин дарахад хаалга дахин онгойх болно.

Лифтэн дотор та товчлуураас хол зогслоо гээд мон сандрах хэрэггвй. Товчлуурын ойр зогсож байгаа хvнд хэддvгээр давхрын товчлуурыг дарж болохыг эелдгээр хэлэхэд таны хvссэн давхрын тоон дээр дарж огно гэдэгт эргэлзэхгвй байна.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №2: Хоггвй хотод амьдарвал хичнээн сайхан.



Дээрх шог зураг амьдрал дээр олон тохиолддог. “Энэ хогийг яана аа, арай дэндvв юм аа” гэж уулга алддаг хэр нь хvний нvд хариулж байгаад хогоо чулуудчихдаг хvн олон. Олон гэж яаж мэдэж байгаа юм гэж vv. Хаашаа л харна хоглорч буй хогийг хараад л тэр.

Дээр нь боловсон, соёлтой байна гэдэг боловсрол эзэмшсэн дипломоор үнэлэгддэггүй. Ходооний хvн хотод ирээд бусдын тав тухыг бодоод хогоо халааслаад явж байхад, хэд хэдэн сургуулийн диплом овортолж, ганган сайхан хувцасласан мортлоо идсэн чихрийн цаас, уусан ундааныхаа савыг чулууддаг нэгэн бий.

Заавал бид бусдын хаясан хогийг тvvгээд л эх оронч, энэрэнгvй сэтгэлтэн, нийгмийн баатар болох гээд байх шаардлага байхгvй. Бид "тарьсан" хогоо оороо цэвэрлэхдэг, бусдад "хог битгий хаяач ээ" гэдгийг ойлгуулчихдаг бол л болох нь тэр. Тэгж чадвал Азийн цагаан дагина Улаанбаатарт амар сайхандаа жаргаж, аж тороод байна гэсэн vг.

Энэ удаагийн Соёлын довтолгоо хичээл №2 "Хог" сэдвийн дор та бvхэнд хvрэх болно.

## 1. Намар-самар-хог

Намар болохоор самар гараад, самар харахаар идмээр санагдаад байна уу. Идэж бололгvй яах вэ. Гэхдээ гэртээ хариад идэх хэрэгтэй. Намрын улиралд хамгийн их нvдэнд "хvйтэн" харагддаг хог бол самрын яс. Хаа сайгvй л хуруугаа хохож, хог "vйлдвэрлэсэн" хvмvvc. Эцэст нь хотын гудамж намрын шар навчсаар бус самрын ясаар "гоёж" байна. Ил задгай борлуулж буй самрыг угааж, цэвэрлэлгvй оороор хэлбэл гадаа идсэнээс болж гэдэсний халдварт овчин vvcэх шалтгаан болдог. Оорийгоо хордуулж, ороол бусдад таагvй сэтгэгдэл торvвлэн байж гадаа гудамжинд самар идэх шаардлагагvй. Бvр самар цомохгvй л бол тэсэхгvй байвал ядаж самрынхаа ясыг уутанд хийж байхыг зовлое.

## 2. Энд орох уу тэнд орох уу

Нэг vеэ бодвол нийслэл хотод маань хогийн сав олон болжээ. Харин хогийн саванд хог хийхдээ та нvдээ аньж байгаад шидчихдэг юм биш биз? Зарим хогийн сав хоёр тасалгаатай байдаг.

Дахивар ба энгийн гэсэн. Дахивар гэдэг нь дахин боловсруулж болох ундаа, усны сав.

Харин энгийннд бусад хог хаягдлыг хийдэг гэдгийг сануулахад гэмгвй болов уу. Хэрэв хоёр тасалгаатай хогийн савны бичиг нь арилсан бол ногоон тэмдэглэгээтэй хэсэг нь дахин боловсруулах харин улаан тэмдэглэгээтэй нь энгийн хог хаягдал хийх хэсэг нь юм шvv.

### 3.Орц бол таны гэрийн нэг хэсэг

Паартай байшин паалантай жорлонд амьдардаг хvмvвст хогийг хэрхэн хаях талаар огох зовлогоо байна. Орц бол таны гэрийн нэг хэсэг гэдгийг ойлгож ухаараагvй нэг хэсэг хvн байна. Гэрээсээ л хогоо гаргаж байвал болох нь тэр гэж боддог бололтой.

Хажуу айлынхаа хаалганы хажууд хогоо тавьдаг, орцондоо гаргаад шидчихдэг хvмvвс байвал энэ бvдvвлэг хэрэг шvv. Хогоо хаяхдаа амсрыг нь сайтар боогоод хогийн бункер, хэрэв байхгvй бол хогийн цэгт хаяж заншаарай. Зарим байрнууд хогийн бункер, хогийн цэггvйгээс болоод шонгийн мод эсвэл хэн нэгний хаясан хогон дээр давхарлан тавих нь бий. Хэрэв ийм асуудал танд байдаг бол сууц омчлогчдийн холбоондоо хандаж хогийн битvв цэг байгуулахыг шаардах хэрэгтэй. Учир нь та бvхний тав тухтай байдлыг хангах гэж сар бvр хураамж авдаг шvv дээ. Дээрээс нь цонхоороо хогоо шиддэг айлууд бас бий. Цонх бол оргоо гэрт тань гэрэл гэгээ, салхи оруулах зориулалттай болохоос биш хог хаядаг “нvх” биш.

### 4.Миний машин ямар хогийн сав уу

Та арай ингэж бодож байгаа юм биш биз. Таны машин хогийн сав биш бол Улаанбаатарын гудамж, талбай бvр биш шvv. Ганган сайхан машиныхаа цонхоор ус ундааныхаа савыг чулуудаж байгаа бол Та их хотын соёлтой нэгэн хэрхэвч биш гэдгийг ойлгож, ухаарна уу.

## СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №2: Баруун гарын дvрэм

Арван жилд байхад багш нарын “Баруун гарын дvрэм, баруун гарын дvрэм” гэж ягштал сануулдаг байсан veийг мартсан хvмvвс бишгvй байх шиг байна энэ хотод. Дэлгvвvр

хоршоо, ер нь хаа газар шатаар огсох уруудахад баруун гар талаа дагаад явбал солонгос кино шиг зорж чадахгүй чи наашаа, би цаашаа гэдэг асуудал үүсэхгүй шүү дээ.

Зам хондлон гарахдаа баруун гар талаа баримтлаарай

Ялангуяа ногоон гэрлээр зам хондлон гарах үед баруун гарын дүрмээ баримталдаггүйгээс яг л “америк холбомбог” тоглох гэж байгаа хүмүүс шиг оод оодоосоо тулан, морголдохоос наахнуур болно.

Урсдаг шатаар явахдаа баруун гар талаа баримтална

Урсдаг шатны оргон зэрэгцэж зогссон хоёр хүний хэмжээтэй ижил. Энэ нь урсдаг шатаар зорчихдоо зэрэгцээд зогс гэсэн үг биш. Харин аль нэг тал, ихэвчлэн баруун гар тал уруугаа шахаж зогсоод зүүн гар талаар нь яарсан хүмүүст явах зай гаргаж ог гэж байгаа юм. Гэтэл манайд олон хүн яг голд нь зогсчихдог. Олон янзын шалтгаанаар яарч буй тэр хүнд та саад болохыг үүсэхгүй байгаа биз дээ. Зөвхөн урсдаг шат гэлтгүй ер нь шатаар огсохдоо баруун талаа, буухдаа мон баруун талаа барьж яваарай.

Гудмаар алхахдаа ч баруун гар талаа барьж явна

Оргон уудам нутагтайгаасаа болдог юм уу Монголчууд цуварч явах дургүй улс. Сугадалцаж, хэлхэлдээд л хориглолт хийж байгаа улс мэт явах нь олон. Гэтэл хотын гудамж маань одор ирэх тусам нарийсч байгааг Та бүхэн харж байна. Тиймээс бусдадаа товог удахгүй байх үүднээс баруун гар талаа барин /мон л ногоо талд хүмүүс явах боломжийг бий болгоно/ цувраад явж байгаарай. Хоёул, гурвуул гудамж хондолсон явах, ганцаар атлаа мон хойд талынхаа хүмүүст боломж олголтгүй зам хондолсон алхах, олон хүнтэй гудманд явж байгаад гэнэт зогсох зэрэг нь бүдүүлэгт тооцогдоно. Учир нь та ходоо талд ганцаар явж байгаа бус олон хүн ажиллаж, амьдардаг том хотод амьдарч байгаа гэдгээ бүү мартаарай.

Хаалгаар гарч байгаа хүмүүст зай тавьж огно

Хаалгаар орж гарахад мон баруун гарын дүрэм шаардлагатай. Та баруун гар талдаа байрлалаа эзлэснээр хаалгаар гарч байгаа хүмүүст зай тавьж огно. Хаалгаар хүмүүс гарсны дараа та орох учиртай. Тиймээс хаалгаар гарч байгаа хүмүүстээ юун түрүүнд зай тавьж огч байгаарай.

Хотын хүн танд амжилт хүсье.

Олонтойгоо амьдрах гэдэг асар их хариуцлага, соёл шаардсан ажил. Та хувийн эдлэндээ лаагаа иднэ үү, луувангаа иднэ үү таны дур байж болох ч орон сууцанд бол оор хэрэг. Таны хар гэртээ хаан, бор гэртээ Богд байх эрх чолоо хажуугийн айлын хаалганы яг наахна дуусгавар болно.

Бид энэ удаад Соёлын довтолгоо хичээлээрээ орон сууцанд хэрхэн соёлтой аж торох талаар зовлох болно.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №3: Паалантай жорлон, паартай байшинд амьдрах нь... ..

БАЙРНЫ ЧИНЬ ОРЦ ТАНАЙ ГЭРИЙН ҮҮД ЮМ...

Орцны үүдэнд, лифтэн дотор, шатны хажууд хогоо тавьдаг байсан айлууд бүр сүүлдээ айлын хаалганы гадна хогоо авчраад шидчихдэг болчихсон байна шүү хэмээн хорш маань ярилаа. Нээрээ л бункер онгойлгоод хогоо хийх, доод давхар луу буугаад хогоо хаяхаасаа ч залхуурдаг хүмүүс олширч. Бараг л хаалгаа онгойлгоод “хаана буухыг гарын хүч мэд” гээд л шидчихдэг гэхэд хилсдэхээргүй орцнууд байна.

Үүнээс гадна нар, салхи үзэх зориулалт бүхий цонхоор хог хаяхыг хатуу хориглоно. Таны хаясан хог хэн нэгний эд хоронгод хохирол учруулж болох юм шүү.

Хогтой холилдох уу, цэвэрхэн амьдрах уу гэдэг иргэн бүрийн хвчин чармайлтаас шалтгаалдаг юм шvv. Дээр нь лифтэнд нусаа нийх, швлсээ хаях, орцонд тамхи татахыг “цээрлэх” хэрэгтэй.

БУЯН УУ ЭСВЭЛ...



Эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд хэмээн тэнгэр бурхандаа оргодог цай, сvvний дээж маань бусдын уур бухимдлыг торvvлдэг байж болохгvй.

Ямар сайндаа л орцны vvдэнд гуйсан, уурласан, занасан ил захидлууд ховорч байх вэ дээ.

Ёс заншил, уламжлалаа овлоно гэдэг сайн хэрэг. Гэвч суурин амьдралд нийцvvлэх шаардлагатай зvйлс гэж бий. Тvvний нэг нь дээр дурдаад буй цайны дээж оргох ёс.

Цонх, тагтнаасаа дээж оргож байгаа иргэд бусдын эд хоронгийг бохирдуулан, бухимдлыг торvvлж байгаагаа ойлгож, ухааран гэрээсээ гарч ёсыг ёс чигээр нь вйлдэх хэрэгтэй.

Нэмж хэлэхэд машин дээр дуссан сvvний толбо энгийн арчилтаар арилах нь ховор. Учир нь сvvний найрлаганд уураг, тос, лактоз мон бусад микро элементvvд байдаг учраас машин дээр толбо тогтож, угаалгын газар очихоос оор сонголт vлдээдэггvй гэдэгтэй жолооч нар санал нийлэх биз ээ.

“БОЛД ОО, БИ ИРЧИХЛЭЭ”

Ногоон гэрэл асангуут л “хvvш гэрэл асчихлаа, яваач” гэж "ярьдаг" шигээ байрны гадаа бас дуут дохиогоор "ярьдаг" хvmvvc бий. Болдоо би ирчлээ, хурдан яваач ээ зэрэг харилцан ярианаас эхлээд амьдралаа тэд сигналаар хvvрнэн огvvлдэг.

Тэд олгийтэй бяцхан vрсээс эхлээд отол буурайн амгалан тайван байдлыг алдагдуулж байгаа нь соёлын ямар тvвшинд байгаагаа харуулдаг.

Уг нь Замын ходолгооний дvрэмд зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, суурин газрын гаднах замд гvйцэж тvрvvлэх вeдээ бусад жолоочид анхааруулах зорилгоор дуут дохио хэрэглэхийг зовшоорч бусад вeд дуут дохио ашиглахыг хориглоно гэсэн байдаг.

Тиймээс орон сууцны гадна дуут дохио ашиглахаасаа омно хvvхэд унтаж байх вий, хогшид амарч байх вий гэж нэг бодоод vзээрэй.

ТА ХЭН НЭГНИЙ АМЬ НАСАНД "ЗАНАЛХИЙЛЖ" БАЙГАА ЮМ БИШ БИЗ

Байрныхаа гадаа машинаа тавих гэж байгаа бол та эхлээд сайн хараарай. Орцны vvд хаагаад машинаа байрлуулах гэж байгаа юм биш биз. Хvvхдээ салхилуулахаар хvvхдийн тэрэг тvрээд гарч буй ээжvvд, хол муутай хогшдийн замыг хаасан эсэхээ шалгаарай.



Муугаар бодоход хvний бие муудаад тvргэн тусламж дуудахад яаралтай вйлчилгээ эзvvлэхэд саад болохоор газарт машинаа битгий тавиарай гэж сануулж байна. Ихэнх байр машины зогсоол муутайгаас болоод аргаа барсан жолооч нар гэртээ орж чадахгvй болтол машины хааж тавьсан харагддаг учраас vvнийг сануулж байгаа юм шvv.

Зогсоол ярьсных байрны гадаа машинаа тавихдаа аль болох бусдадаа саад болохгvй, зай бага эзлэхээр тавьж байгаарай. Мон яалт ч vгvй хэн нэгний машиныг хааж тавихаар бол атга цаас олоод дугаараа бичиж vлдээхээ мартав аа.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №4: Кино театрт биднийг юу бухимдуулдаг вэ...

Алжаал, ядаргаагаа тайлах, анд найз, гэр бvлийнхэнтэй цагийг зугаатай онгорvлэхээр кино, жvжиг, дуурь юу ч юм vзэж суутал хэн нэгний утасны хонх чанга гэгч нь “орилох” тэр мочийг vгээр хэлэхийн аргагvй.

Утас нь дуугарсан “эрхэм” дуудлагыг таслалгvй “Ярих боломжгvй байна. Дараа ярья” гэхэд таны уур бухимдал, гомдол, цохрол нэгэн зэрэг ходролж, хvvхэлдэйн кинон дээр гардаг уурын яндан шиг л болдог биз дээ?

Энэ мэтчилэн оноох амрах, сэтгэлийн таашаал эдлэх сайхан цаг хугацаа хэн нэгний бvдvvлэг, соёлгvй байдлаас болж нуран унах нь бий. Ингээд л уур хvрсэн тэр хэсэг цаг моч, тvvний дараах хэсэг хором ч утгагvй болдог гэдэгтэй та санал нийлэх байх. Тэгвэл бид энэ удаагийн хичээлээрээ кинотеатрт хэрхэн бусдад саад болохгvй байх талаар мэдээллийг хvргэж байна.

Яалт ч vгvй хоцорсон бол уучлалт гуйгаад, хvmvсийн хажуугаар зорохдоо нvvрээ хvн рvv нь харуулж зорохийг хичээгээрэй

Театрт хүмүүсийг тавгуй болгодог хамгийн эхний зүйл бол ЦАГААСАА ХОЦРОХ. Яг сайхан тухлаад суучихсан, кино эхэлчихсэн байхад гэрэл тусгаад л орж ирнэ дээ. Тэгээд уучлаарай ч байхгүй бүр дээр нь яг нүүрэн дээр богсоо “наачихна” гээч. Хэрэв та кино үзэхээр шийдсэн бол аль болох цагаасаа хоцрохгүй байхыг хичээх хэрэгтэй. Яалт ч үгүй хоцорсон бол уучлалт гуйгаад, хүмүүсийн хажуугаар зорохдоо нүүрээ хүн рүү нь харуулж зорохийг хичээгээрэй.

**ХҮҮХЭД ХАРАХ ХҮНГҮЙ БОЛ КИНО ҮЗЭХ ШААРДЛАГАГҮЙ.** Ингэж хэлэхэд хатуудахгүй болов уу. Кино театрт тасалбар болон танилцуулга дээр хэдэн наснаас дээш хүн үзэх боломжтой талаар мэдээлэл байдаг. Гэвч зарим хүн том хүний кинон дээр бага насны хүүхэдтэйгээ орох, аймшгийн, адал явдалт гэх мэт дуу чимээ ихтэй кинонд нярай хүүхдээ дагуулан ирэх нь бий. Нялх хүүхэд нь дуу чимээнд дэрхийн цочиж уйлахтай та ч бас таарсан биз ээ. Энэ мэтчилэн асуудлаас болж нэг танхимд үзвэр үзэж буй хүмүүст тухгүй байдал үүсдэг гэдгийг анхаарахад илүүдэхгүй.

Дараагийн зүйл кинотеатрт орж ирсэн л бол УТАСНЫХАА ДУУГ ХААГААРАЙ. Дээр дурдсанчлан гэнэт л элдэв янзын утасны хонх “чарлаж”, аваад хэлж байгаа үг нь “Завгүй байна дараа ярья”. Хэрэв та утсаар ярих боломжгүй бол таслаад автоматаар хариу илгээх шийдлийг ухаалаг утас хэдийнэ олгочихсон шүү дээ.

Кинотеатрт бас нэг зүйл үнэхээр тавгуй байдлыг бий болгодог. Энэ нь СУУДЛЫН АРААС ОШИГЛОХ . Зай багатайн улмаас ийм зүйл тохиолдоод байна уу эсвэл оор шалтгаан байна уу гэдгийг мэдэхгүй. Ямартай ч таны олно хүн сууж байгаа гэдгийг санаад аль болох холоороо урд талынхаа суудалд хүрэхгүй байхыг хичээгээрэй.

Хэрэв та утсаар ярих боломжгүй бол таслаад автоматаар хариу илгээх шийдлийг ухаалаг утас хэдийнэ олгочихсон

Тогсголд нь ХОГ. Кино дууслаа та уусан ундааны сав, идсэн корныхоо хайрцгийг суудлынхаа дор “мартчихсан” юм биш биз. Мэдээж дараагийн үзвэрээс олно цэвэрлэгээ хийх нь ойлгомжтой хэдий ч та оорийнхоо тарьсан хогийг аваад гарах хаалганы дэргэдэх хогийн саванд хийчихвэл бусдад үнэхээр сайхан санагдахаас гадна танд ч сайхан сэтгэгдэл үлдэнэ гэдэгт итгэлтэй байна. Үзвэр дууссаны дараа гэрэл асахтай зэрэгцээд л чихцэлдчихнэ. Түүний дараа танхим дүүрэн хог үлдэж байгааг харах ямар “сэтгэл өвтгөсөн” хэрэг гэдгийг хэлэхэд илүүдэхгүй болов уу.

За тэгээд амралтын өдрүүд ч хаяанд ирлээ. Кино үзэхээр шийдсэн бол бидний бэлтгэсэн бяцхан хичээлийг санахад илүүдэхгүй биз ээ.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №5 Та зогсож болно, гэхдээ бусдад СААД БОЛОХГҮЙГЭЭР...

Их хотын хүмүүс дандаа л яарч явдаг. Тиймээс хаалга, орц, гарц, шат таглан яах гээд байгаа нь мэдэгдэхгүй зогсох, утсаар ярих, юм зарах зэрэг вйлдлийг хийхгүй байхыг хичээгээрэй.

Морьтой давхиж яваад дуртай газраа зогсох, эргэх, буугаад морь харах, орхиж явах гэх мэт вйлдэл нь одооноос даруй зуун жилийн омнох билээ.

АВТОМАШИНЫ ЗОГСООЛЫН ТУХАЙ

Орон сууцны барилга, оффисуудын хонгилын давхарт байрлах автомашины зогсоол бүр нь эзэнтэй байдаг. Одоогийн ханшаар нэг айл 10-20 саяар тэрхүү зогсоолыг худалдан авдаг. Тиймээс та орон сууцны хонгилд зогсоол худалдан аваагүй л бол автомашинаа байрлуулж болохгүй. Мон гадаа байрлах гараажууд ч хүний эзэмшил тул хаалгыг нь хааж зогсохыг хориглодог.

Явган хүний гарц, орцыг хааж зогсож болдоггүй. Учир нь том хотод олон хүн амьдардаг тул тэдний дотор хүүхдээ тэргэнд түрсэн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч зорчдог. Тухайн хүмүүст саад болохгүйгээр автомашинаа байршуулах ёстой.

Муугаар бодоход хүний бие муудаад түргэн тусламж дуудахад яаралтай вйлчилгээ үзүүлэхэд саад болохоор газарт машинаа битгий тавиарай гэж сануулж байна. Хэрвээ тухайн орчинд байршуулах газар олдохгүй бол холхон газарт машинаа байршуулаад оороо алхаж яваарай.

Замын ходелгоонд оролцож байгаа автомашин гэнэт зогсох ослын шаардлага гараагвй л бол зогсох учиргвй. Та зогсохоор шийдсэн бол мэдээж дохиогоо огоод, эгнээ байраа зов эзэлнэ.

## ЯВГАН ХҮМҮҮСТ Ч ЗОГСОХ ХАМААТАЙ ЮУ?

Явган явж буй хvmvвст ч хэзээ, хаана зогсох нь хамаатай. Хэрвээ та тасралтгвй вргэлжлэх хvmvвсийн урсгал дунд явж буй бол гэнэт зогсох, гэнэт эргэж буцах вйлдэл нь арын хvmvвсийг гэмтээхэд ч хvргэж болзошгвй. Тиймээс гэнэт зогсохоор болсон бол алхалтаа аажмаар удаашруулан хажуу тийш зам тавин зогсох ёстой.

Та хээр талд ганцаараа яваагвйн учир яах нь мэдэгдэхгвй гэнэт зогсох, утсаар ярих нь бусдад саад болсон, бvдvvлэг зан вйлд тооцогдоно гэдгийг битгий мартаарай.

Аливаа газар зогсож байхдаа та бусдад садаа болохгвй байх учиртай. Урт встэй бол зэрэгцээ хvндээ хvрэхвйцээр вcээ сэгсрэх, шудрах, хувцсаа дvвгvvрдэх гэх мэт вйлдлvvдээс татгалзаарай.

Хотын хvн танд амжилт хvсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №6 Шоолж байсан хvmvвстэйгээ адил сэжиг хvрэм болжээ..

